

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ДУГААР	151021-9
ХАВСРАЛТ	1
ОГНОО	2022 оны 04-р сарын 14-ний өдөр
УТГА	Премиум Дистрибьюшн ХХК-ийн үйл ажиллагааны чиглэл, оноосон нэр, оршин байгаа хаягийг өөрчлөх тухай

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн 100 хувийн охин компани Премиум Дистрибьюшн ХХК-ийн Дүрмийн 8.2, 9.1.4 болон 9.1.12 дах заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Премиум Дистрибьюшн ХХК-ийн түгээлтийн төвийн үйл ажиллагааг Компанид шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Премиум Дистрибьюшн ХХК-ийн оноосон нэрийг Сэнтрал Фүүдс ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
3. Сэнтрал Фүүдс ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлээс “барилгын материалын худалдаа”-г хасаж, Сэнтрал Фүүдс ХХК-ийн бусад үйл ажиллагааны чиглэлийг энэ тогтоолын 4-т заасан нэршлээр шинэчлэн найруулсугай.
4. Сэнтрал Фүүдс ХХК-ийн Дүрмийн 4.1 дэх заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй. Үүнд:
 - Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл;
 - Жимс болон хүнсний ногоо боловсруулах;
 - Бууз, баншны үйлдвэрлэл;
 - Мах, махан бүтээгдэхүүний худалдаа
 - Жимс болон хүнсний ногооны худалдаа
 - Бууз, баншны худалдаа
 - Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа;
 - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.
5. Сэнтрал Фүүдс ХХК-ийн оршин байгаа хаягийг Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Тауэр, 11-н давхар хэмээн өөрчлөхийг зөвшөөрсүгэй.
6. Сэнтрал Фүүдс ХХК-ийн шинэчилсэн Дүрмийг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
7. Сэнтрал Фүүдс ХХК-ийн шинэчилсэн Дүрмийг Компанийг төлөөлөн баталгаажуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д зөвшөөрсүгэй.

ДУГААР 151021-9
ОГНОО 2022 оны 04-р сарын 14-ний өдөр

8. Сэнтрал Фүүдс ХХК-ийн шинэчилсэн Дүрмийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар болон бусад холбогдох байгууллагад бүртгүүлэх, хяналтын дугаар авах, тамга тэмдэг авах зэргийг оролцуулаад дээрх шийдвэрийг бүрэн гүйцэд хэрэгжүүлэхэд шаардлагатай буюу зүйтэй хэмээн үзсэн бүх арга хэмжээг авч ажиллахыг Сэнтрал Фүүдс ХХК-ийн Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)

ДУГААР 151021-9
 ОГНОО 2022 оны 04-р сарын 14-ний өдөр

		ЗӨВШӨӨРСӨН	ТАТГАЛЗСАН	ТҮДГЭЛЗСЭН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:	А.ГАНХУЯГ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	А.ГАНБОЛД			
	О.БАТМӨНХ			
	Г.БАТ-ЭРДЭНЭ			
	Г.ЧИНЗОРИГ			
	Б.БАТ-ЭРДЭНЭ			
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:	Н.ЭНХБОЛД			
	Ч.МЭРГЭН			
	ГАРИ СТИВЕН БИОНДО			
ТОГТООЛЫН БАТЛАГДСАН ХУВЬ:		100%		